



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/594

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэбүрэн сумын харьяат гавьяат малчин Л.Баттулга агсаны буяны ажилд буцалтгүй тусламж 100 000 төгрөг, Ховд аймгаас шинээр гавьяат цол хүртсэн Н.Цолмон, Д.Ганболд, Б.Жамсран нарт баяр хүргэж хүндэтгэл үзүүлэхэд 1 050 000 төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт яамдаас санал авах хэлэлцүүлэг зохион байгуулсан зардалд 1 020 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 170 000 төгрөг /Хоёр сая нэг зуун далан мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

